



ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/60

Улаанбаатар хот

Төрийн цахим үйлчилгээний “Хөдөлгөөнт хурдан цэг”-ийн
үйл ажиллагааны журам батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 32¹ дүгээр зүйлийн 32¹.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн цахим үйлчилгээний “Хөдөлгөөнт хурдан цэг”-ийн үйл ажиллагааны журмыг нэгдүгээр хавсралтаар, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг шалгах хуудсыг хоёрдугаар хавсралтаар, хэвийн үйл ажиллагааг үнэлэх үнэлгээний хуудсыг гуравдугаар хавсралтаар, үйлчилгээ үзүүлэх процессын зураглалыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Төрийн цахим үйлчилгээний “Хөдөлгөөнт хурдан цэг”-ийн үйл ажиллагааны журам, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг шалгах хуудас, хэвийн үйл ажиллагааг үнэлэх үнэлгээний хуудсыг холбогдох нэгж, албан хаагчдад танилцуулж, дагаж мөрдүүлэхийг Үйлчилгээний нэгдсэн төвийн зохицуулалтын газар (М.Уранчимэг), Чанар хяналтын газар (И.Хайратбек)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын газар (Д.Жавхлан)-т даалгасугай.

ДАРГА



П.БАТБААТАР

1425010291

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын
даргын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн
А/М дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ “ХӨДӨЛГӨӨНТ ХУРДАН ЦЭГ”-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар” гэх)-аас хүн, хуулийн этгээд (цаашид “үйлчлүүлэгч” гэх)-д төрийн цахим үйлчилгээг хурдан шуурхай, тэгш, хүртээмжтэй хүргэх “Хөдөлгөөнт хурдан цэг” (цаашид “Хөдөлгөөнт цэг” гэх)-т тавигдах шаардлага, баримтлах зарчим, үйл ажиллагаатай холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2. “Хөдөлгөөнт цэг”-ээр хүн амын төвлөрөл ихтэй, алслагдсан бүсийн үйлчлүүлэгчид төрийн цахим үйлчилгээг хурдан шуурхай, тэгш, хүртээмжтэй хүргэх, төрийн цахим үйлчилгээтэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах зориулалт бүхий тоноглогдсон тээврийн хэрэгслийн ашиглалт, бүрэн бүтэн, аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг хангах харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Энэхүү журам нь “Хөдөлгөөнт цэг”-ээр дамжуулан операторын горимоор төрийн цахим үйлчилгээг үйлчлүүлэгчид хүргэж байгаа холбогдох нэгж, албан хаагчид хамаарна.

Гурав. Нэр томъёоны тодорхойлолт

3.1. “Хөдөлгөөнт цэг” гэж төрийн цахим үйлчилгээг үйлчлүүлэгчид хурдан шуурхай, тэгш, хүртээмжтэй хүргэх, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах зориулалт бүхий тоноглогдсон тээврийн хэрэгслийг;

3.2. “Операторын горим” гэж үйлчлүүлэгч хөдөлгөөнт цэгээс биечлэн ирж, үйлчилгээний ажилтанд хүсэлт гарган Засгийн газраас тогтоосон үйлчилгээний жагсаалтын дагуу төрийн байгууллагын үйлчилгээг цахимаар авах хэлбэрийг;

3.3. “Үйлчилгээний ажилтан” гэж үйлчлүүлэгчид төрийн цахим үйлчилгээтэй холбоотой зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад цахимаар шилжүүлж, шийдвэрлүүлэх, хариу өгөх, мэдэгдэх ажлыг шуурхай зохион байгуулах ажилтныг;

3.4. “Тээврийн хэрэгслийн ашиглалт” гэж тээврийн хэрэгслийг хадгалах, техникийн үйлчилгээ, засвар хийх, шатахуун тосолгооны болон ашиглалтын бусад материалаар хангах, техникийн хяналтыг зохион байгуулж явуулах зэрэг тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаанд техникийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангахад чиглэгдсэн техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээг;

3.5. “Жолооч” гэж тээврийн хэрэгсэл жолоодож яваа хүнийг;

3.6. “Гэнэтийн саатал” гэж байгалийн давагдашгүй хүчин зүйл, техникийн эвдрэл, гэмтэл, шатах, тослох материалын хүрэлцээгүй байдал бий болох, тоног төхөөрөмж, системийн хэвийн үйл ажиллагаанд алдаа доголдол гарах, хөдөлгөөнт цэгийн холбогдох албан хаагч эрүүл мэндийн шалтгаанаар ажиллах боломжгүй болохыг.

Дөрөв. Хөдөлгөөнт цэгийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

- 4.1.дэвшилтэт техник, технологи, инновацад тулгуурласан байх;
- 4.2.мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа хурдан шуурхай, хялбар байх;
- 4.3.төрийн цахим үйлчилгээтэй холбоотой хүн, хуулийн этгээдийг зөвлөгөө мэдээллээр хангах;
- 4.4.мэдээлэл, үйлчилгээ нь ойлгомжтой, үнэн зөв, бүрэн байх;
- 4.5.төрийн цахим үйлчилгээ нь хүн, хуулийн этгээдэд тэгш хүртээмжтэй байх;
- 4.6.ялгаварлан гадуурхахгүй, жендерийн эрх тэгш байдлыг хангах;
- 4.7.мэдээллийн эзний зөвшөөрлөөр цахим үйлчилгээг хүргэх;
- 4.8.мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн, аюулгүй байдлыг алдагдуулахгүй байх.

Тав. Норматив эшлэл

- 5.1.MNS 5027:2001 "Дэлгэц бүхий тоног төхөөрөмжтэй ажиллах эрүүл ахуй. Эргономикийн ерөнхий шаардлага";
- 5.2.MNS 5881:2008 "Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний ажилтанд тавих шаардлага";
- 5.3.MNS 5882:2008 "Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний ажлын байранд тавигдах шаардлага";
- 5.4.MNS 6356:2012 "Мэдээлэл, шуудан харилцаа, холбооны хөдөлгөөнт салбар";
- 5.5.MNS 6984:2022 "Төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлэхэд тавих ерөнхий шаардлага";
- 5.6.MNS 4598:2025 "Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавигдах ерөнхий шаардлага".

Зургаа. Хөдөлгөөнт цэгт тавигдах шаардлага

- 6.1.Хөдөлгөөнт цэг нь дараах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байх. Үүнд:
 - 6.1.1.сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр;
 - 6.1.2.цахилгаан нөөцлүүр;
 - 6.1.3.халаалтын төхөөрөмж;
 - 6.1.4.хөргүүрийн төхөөрөмж;
 - 6.1.5.заалны нэмэлт гэрэлтүүлэг;
 - 6.1.6.цахилгааны иж бүрдэл;
 - 6.1.7.байршил, чиглэл тогтоогч (GPS);
 - 6.1.8.пин пад төхөөрөмж;
 - 6.1.9.шүүгээ тавиур;
 - 6.1.10.хүлээлгийн сандал;
 - 6.1.11.зөөврийн компьютер;
 - 6.1.12.хэвлэгч, хувилагч төхөөрөмж;
 - 6.1.13.утасгүй интернэтийн төхөөрөмж;
 - 6.1.14.хяналтын камер;
 - 6.1.15.төрийн үйлчилгээний киоск машин;
 - 6.1.16.мэдээллийн дэлгэц (LED);
 - 6.1.17.галын хор, анхан шатны тусламжийн хайрцаг, ослын гурвалжин;
 - 6.1.18.чанга яригч;
 - 6.1.19.бусад.
- 6.2.Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/13 дугаар тушаалаар батлагдсан "Брэндбүүк"-ийн дагуу хаягжилт болон тохижилтыг хийж гүйцэтгэх.

6.3. Үйлчилгээний ажилтан нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, тус газрын хөдөлмөрийн дотоод журам, төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийн үйл ажиллагааны түр журам гэх мэт байгууллагын дотоод хэм хэмжээг мөрдлөг болгон ажиллах.

6.4. Төрийн цахим үйлчилгээг үйлчлүүлэгчид хүргэх процессын зураглал, галын аюулгүй байдлыг хангах, эмнэлгийн анхан шатны тусламж, хөдөлмөр аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ахмад настан, жирэмсэн, 0-2 насны хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүнд дараалал харгалзахгүй үйлчлүүлэх таних тэмдэг, санал, хүсэлт, гомдол хүлээн авах хайрцаг, цахим холбоос, тусгай дугаар зэргийг ил байршуулах.

6.5. Үйлчлүүлэгчийн ая тухтай байдлыг хангасан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг саадгүй, хүртээмжтэй хангах орчин нөхцөлийг бүрдүүлэх.

6.6. Хөдөлгөөнт цэг нь баталсан хуваарь, маршрутын дагуу ажиллана.

Долоо. Хөдөлгөөнт цэгийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага

7.1. Хөдөлгөөнт цэгийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг хангаж тээврийн хэрэгслийг тогтсон хугацаанд, шаардлагатай тохиолдолд тухай бүр үзлэг оношилгоонд оруулж баталгаат байгууллагаар засвар үйлчилгээг хийж гүйцэтгүүлэх;

7.2. Жолооч замын хөдөлгөөнд оролцохоос өмнө тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж аюулгүй байдлын шалгах хуудсыг бөглөж холбогдох албан тушаалтанд хүргүүлнэ. Үйлчилгээ үзүүлэх хугацаанд хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангаж, ажлын цаг дууссаны дараа зориулалтын зогсоолд байршуулах;

7.3. Үйлчилгээний ажилтан үйлчилгээ үзүүлэхээс өмнө бүх тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг шалгаж, ажиллах бэлэн байдлыг хангах бөгөөд ажлын цаг дууссаны дараа бүх тоног төхөөрөмжийг унтрааж, аюулгүй байдлын хуудсыг бөглөж холбогдох албан тушаалтанд хүргүүлэх;

7.4. Жолооч, үйлчилгээний ажилтан нь согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх, хэрэглэсэн үед тээврийн хэрэгсэл жолоодох, үйлчилгээ үзүүлэхийг хориглох;

7.5. Үйлчилгээний асуудал хариуцсан нэгж нь хүн амын төвлөрөл ихтэй, алслагдсан бүсэд үйлчилгээ үзүүлэх цагийн хуваарь, маршрутыг боловсруулж батлуулах, батлагдсан хуваарийн дагуу үйлчилгээ үзүүлэх, холбогдох үйл ажиллагааг зохион байгуулах, хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих, үйлчилгээний талаарх мэдээллийг хүн, хуулийн этгээдэд урьдчилан түгээх ажлыг зохион байгуулах;

7.6. Захиргааны асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж нь хөдөлгөөнт цэгийн хэвийн аюулгүй үйл ажиллагааг хангахад холбогдох зардлыг шийдвэрлэж, хүн, хуулийн этгээдэд төрийн цахим үйлчилгээтэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллах;

7.7. Систем, сургалтын асуудал хариуцсан нэгж нь төрийн үйлчилгээний нэгдсэн систем (оператор), холбогдох тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах, үйлчилгээний ажилтныг сургаж, мэргэшүүлэх.

Найм. Хариуцлага

8.1. Энэхүү журмыг зөрчсөн албан хаагчид холбогдох хууль тогтоомж болон тус газрын хөдөлмөрийн дотоод журам, байгууллагын дотоод хэм хэмжээний дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Ес. Бусад

9.1. Жолооч, үйлчилгээний ажилтан энэхүү журамтай бүрэн танилцаж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

9.2. Урьдчилан төлөвлөгдөөгүй хүчин зүйлийн улмаас хөдөлгөөнт цэгийн үйлчилгээ хэсэгчлэн болон бүрэн зогсохыг "Гэнэтийн саатал" гэж тооцно.

9.3. Энэхүү журам нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

9.4. Журмаар нарийвчлан зохицуулагдаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын дагуу зохицуулна.

--oOo--

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын
даргын 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн
160 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРЭН БҮТЭН, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШАЛГАХ ХУУДАС

Шалгасан:

Автомашинны улсын дугаар:


Шалгасан огноо:

"Хөдөлгөөнт хурдан цэг"-ийн хаяг, байршил:

№	Шаардлага	Хэмжээс, үзүүлэлт	Шаардлага хангасан эсэх
Нэг. Тээврийн хэрэгслийн гадна тал			
1.	дугуй	4 түүнээс дээш	
2.	цонх	3 түүнээс дээш	
3.	гадаад бүрэн бүтэн байдал	Хаалга, их бие, толь,	
4.	явах эд анги	Мотор, хроп	
5.	хажуу, доод хэсгийг шалгах	-	
6.	гэрэл, дохионы бүрэн бүтэн байдал	тоо	
7.	цэвэрлэгээ хийгдсэн эсэх	-	
Хоёр. Дотор тал			
8.	хянах самбарыг шалгах	Шатахууны хэмжээ, моторын даралт, алдааны мэдээлэл	
9.	үйлчилгээний заал	-	
10.	цэвэрлэгээ хийгдсэн эсэх	-	
Гурав. Техник хэрэгслийн хэвийн үйл ажиллагаа			
11.	Компьютер	-	
12.	Дэлгэц	-	
13.	нэмэлт дэлгэц	-	
14.	Гар	-	
15.	Хулгана	утаастай, утасгүй	
16.	хэвлэгч төхөөрөмж	3 үйлдэлт хэвлэгч	
17.	тоон гарын үсэг	тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдээс авсан байх	
18.	хурууны хээ уншигч	digital persona U4500 болон бусад	
19.	дуу, дүрсний IP камер	хэвтээ тэнхлэгт 360° босоо тэнхлэгт 180°	
20.	сүлжээ салаалагч төхөөрөмж	порт	
21.	төлбөр тооцооны төхөөрөмж /пин пад/	V820 болон бусад	
22.	HDMI холбогч	40м	
23.	VGA холбогч	100 см	
24.	сүлжээний толгой	RJ45	
25.	иргэний үнэмлэх уншигч	Gemalto GemPC USB SL	
26.	сүлжээний утас	STP CAT6 кабель /100 500 см/	
Дөрөв. Нэмэлт хэрэгсэл			
27.	дэлгэц (LED)	-	
28.	утасгүй интернэтийн төхөөрөмж	-	

29.	сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр	-	
30.	цахилгаан нөөцлүүр	-	
31.	халаалтын төхөөрөмж	-	
32.	хөргүүрийн төхөөрөмж	-	
33.	заалны нэмэлт гэрэлтүүлэг	-	
34.	цахилгааны иж бүрдэл	-	
35.	байршил, чиглэл тогтоогч (GPS)	-	
36.	шүүгээ тавиур	-	
37.	хүлээлгийн сандал	-	
38.	төрийн үйлчилгээний киоск машин	-	
39.	галын хор, анхан шатны тусламжийн хайрцаг, ослын гурвалжин	-	
40.	чанга яригч	-	
41.	салаалагч залгуур	6-аас дээш оролттой 500	
42.	бусад	-	
Тав. Бичиг хэрэг			
43.	хэвлэгч төхөөрөмжийн хор	сонголтоор	
44.	үдээсний машин	24x6 мм	
45.	цаасны цавуу	35 гр	
46.	бичгийн цаас	A4 хэмжээтэй	
47.	бичиг хэргийн үдээстэй хавтас	A4 хэмжээтэй	
48.	үзгэн бал	хар өнгийн	
49.	ширээний алчуур	илгэн	
50.	төмөр хогийн сав	23x26 см	
51.	тооны машин	19x13 см	
Зургаа. Санал, хүсэлт, зааварчилгаа, мэдээллийн самбар			
52.	процессын зураглал	60x40 см	
53.	галын аюулгүй байдал	60x40 см	
54.	эмнэлгийн анхан шатны тусламж, хөдөлмөр аюулгүй ажиллагааны зааварчилгаа	60x40 см	
55.	цагийн хуваарь, маршрут харагдахуйц газар байршуулсан байх	A4 хэмжээтэй	
Долоо. Үйлчилгээний ажилтны хувцасны стандарт			
56.	ажлын үнэмлэхийн зүүлт	5.5x8.6 см	
57.	ажлын байрны хувцас	Батлагдсан брэндбүүкийн дагуу	
58.	энгэрийн тэмдэг /байгууллагын таних тэмдэг/	1.4x8 см	
Нийт			

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын
даргын 2024 оны 04 дүгээр сарын 17-ний өдрийн
160 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



**“ХӨДӨЛГӨӨНТ ХУРДАН ЦЭГ”-ИЙН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Шалгасан:

Шалгасан огноо:

Автомашинны улсын дугаар:

№	Үзүүлэлт	Шаардлага	Авах оноо /100 оноо/	Үнэлгээ	Тайлбар
Нэг. Үйлчилгээний цэгийн үзэмж, тохижилт			50		
1.	гадаад үзэмж		10		
2.	цагийн хуваарь харагдахуйц газар байршуулсан байх		10		
3.	цэгийн дотоод үзэмж, тохижилт		10		
4.	үйлчлүүлэгч тав тухтай үйлчлүүлэх нөхцөл бүрдүүлсэн байдал		10		
5.	үйлчилгээний цэгийн гэрэлтүүлэг		10		
Хоёр. Үйлчилгээний салбарын цэвэрлэгээ			20		
6.	цэгийн цэвэрлэгээ, тохижилт эмх цэгц		10		
7.	байгууллагын эд хөрөнгийн аюулгүй байдал /цоож, лац/		10		
Гурав. Мэдээллийн самбар			15		
8.	үйлчилгээний талаарх танилцуулга зөв байршсан байх		5		
9.	танилцуулга, түүний мэдээллийн агуулга ижил, шинэчлэгдсэн байх		5		
10.	санал хүсэлт талархал гомдлыг хүлээж авах суваг байгаа эсэх		5		
Дөрөв. Бусад шаардлага			15		
11.	хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй эсэх		10		
12.	ахмад настан, жирэмсэн, 0-2 насны хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүнд дараалал харгалзахгүй үйлчлүүлэх таних тэмдэг байршуулсан эсэх		5		
Нийт			100 оноо		

БАТАЛГААЖУУЛАЛТ	
Хяналт хийсэн албан тушаалтны нэр:	Хүлээн зөвшөөрсөн ажилтны нэр:
/овог, нэр/	/овог, нэр/
/гарын үсэг/	/гарын үсэг/

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын
даргын 2015 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн
А/20 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



“ХӨДӨЛГӨӨНТ ХУРДАН ЦЭГ”-ЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ПРОЦЕССЫН ЗУРАГЛАЛ

